



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/176

Рашаант

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, дэх хэсэг, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Монгол Улсын засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр өргөдөл гаргасан 25 иргэнд 19982м² газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хавсралт ёсоор өмчлүүлсүгэй.

2.Иргэдийн өмчилж авсан газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж хүлээлгэн өгөх газрын улсын бүртгэлд бүртгэх газар өмчлөлийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг газрын даамал Б.Берденбек-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг багийн засаг дарга Е.Нурлан-д даалгасугай.

ДАРГА  Б.СЕРИКБОЛ

